Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ЗДТГ	557.4	6.5	(550.9)	0.1
ОНХС	14,366.9	7,366.9	(7,000.0)	99.9
ДҮН	14,924.3	7,373.4	(7,550.9)	100.0

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,033,357.1 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 4,380,279.4 мянган төгрөг болж, 346,922.3 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал				
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,282,616.0	2,456,077.1	173,461.1	56.1
Өмч: - төрийн			-	-

Хуримтлагдсан үр дүн	1,176,470.6	1,378,531.8	202,061.2	31.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	574,270.5	545,670.5	(28,600.0)	12.5
Дүн	4,033,357.1	4,380,279.4	346,922.3	100.0

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 346,922.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2022.12.20-ний өдрийн хуралдаанаар 10/05 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 510,049.0 мянга, хүү торгуулийн орлогыг 40,000.0 мянга, нийт 550,049.0 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2023.07.07-ний өдрийн 13/02 дугаар тогтоолоор 69,124.9 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	579,173.9	519,811.3	(59,362.6)	89.8
ЦХТА рлого /суутган/	169,840.0	186,082.3	16,242.3	109.6
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	4,000.0	10,437.3	6,437.3	260.9
Бууны татвар	3,225.0	2,070.0	(1,155.0)	64.2
ИОТХ	15,000.0	18,560.9	3,560.9	123.7
Улсын тэмдэгтийн хураамж	15,000.0	1,167.0	(13,833.0)	7.8
Хадгаламжийн хүүгийн орлого	42,000.0	45,140.8	3,140.8	107.5
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	9,400.0	9,490.7	90.7	101.0
Малд ногдуулах албан татвар	83,684.9	31,389.5	(52,295.4)	37.5
Газрын төлбөр	170,000.0	63,722.5	(106,277.5)	37.5
дуудлага худалдаа	4,800.0	1,932.0	(2,868.0)	40.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,500.0	16,729.4	7,229.4	176.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	52,224.0	131,708.9	79,484.9	252.2
ТТАМАТөлбөр	500.0	300.0	(200.0)	60.0
Бусад татвар		1,080.0	1,080.0	#DIV/0!
2.Татварын бус орлого	40,000.0	89,821.0	49,821.0	224.6
2.1.Хүү торгуулийн орлого	40,000.0	89,821.0	49,821.0	224.6
Нийт дүн	619,173.9	609,632.3	(9,541.6)	98.5

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 98.5 хувь буюу 9,541.6 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 16,242.3 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 6,437.3 мянга, иргэний орлого тодорхойлох хуудсаар хувь хүний албан татвар 3,560.9 мянга,

хадгаламжийн хүүгийн орлог 3,140.8 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 90.7 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 7,229.4 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 79,484.9 мянга, хүү торгуулийн орлогыг 49,821.0 мянган төгрөгийг тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин бууны албан татвар 1,155.0 мянга, улсын тэмдэгт хураамж 13,833.0 мянга, газрын төлбөр 106,277.5 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 200.0 мянга, газрын дуудлага худалдаа 2,868.0 мянга, малын хөлийн албан татвар 52,295.4 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөж орлого төвлөрөөгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 25,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 38,102.4 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн өвс тэжээлийн орлогоос 12,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,957,404.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,638,157.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,109,405.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 528,752.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

Хүснэгт №14. Төсвийн гүйцэтгэл /мянган төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Нийт зарлага ба зээлийн дүн	1,957,404.2	1,638,157.9	291,074.7	83.7
70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	160,608.9	159,963.4	645.500	99.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	157,008.9	156,363.4	645.5	99.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	3,600.0	3,600.0	0.0	100.0
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	750,367.4	717,036.2	5,159.600	95.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	487,437.6	483,845.9	3,591.7	99.3
80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	93,874.8	93,057.7	817.1	99.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	5,200.0	4,590.0	610.0	88.3
80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн			0.0	#DIV/0!
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	30,000.0	29,881.1	118.9	99.6
81701 Байгаль орчныг хамгаалах	116,000.0	87,828.4	28,171.6	75.7
82212 хур хог хаягдал, орчны бохирдол	17,855.0	17,833.1	21.9	99.9
70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт	766,959.5	528,752.7	238,206.8	68.9
80904 Нийгмийн зориулалттай барилга	303,025.7	144,222.2	158,803.5	47.6
83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	229,551.1	241,362.8	-11,811.7	105.1
83402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр	64,638.5	43,092.4	21,546.1	66.7
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 83403	53,365.8	53,365.8	0.0	100.0
83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	83,684.9	14,016.0	69,668.9	16.7

83406 ОНХС -бусад	32,693.5	32,693.5	0.0	100.0
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	54,471.1	54,466.0	5.1	100.0
80112 Нийтлэг үйлчилгээ	54,471.1	54,466.0	5.1	100.0
71702 Соёл урлаг	23,089.0	21,532.5	1,556.5	93.3
80112 Нийтлэг үйлчилгээ	23,089.0	21,532.5	1,556.5	93.3
71801 Сургуулийн өмнөх боловсрол	45,253.0	43,743.6	1,509.4	96.7
80112 Нийтлэг үйлчилгээ	45,253.0	43,743.6	1,509.4	96.7
71802 Ерөнхий боловсрол	116,655.3	111,681.9	4,973.4	95.7
80112 Нийтлэг үйлчилгээ	116,655.3	111,681.9	4,973.4	95.7
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	40,000.0	981.6	39,018.4	2.5
82611 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	40,000.0	981.6	39,018.4	84.2

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2022.12.20-ний өдрийн хуралдаанаар 10/05 дугаар тогтоолоор нийт 1,731,791.3 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2023.07.07-ний өдрийн 13/02 дугаар тогтоолоор 225,612.9 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	160,608.9	131,480.9	29,128.0
Засаг даргын Тамгын газар	750,367.4	606,719.0	143,648.4
Сургууль	116,655.3	111,655.3	5,000.0
Цэцэрлэг	45,253.0	40,253.0	5,000.0
Эрүүл мэндийн төв	51,471.1	40,471.1	11,000.0
Соёлын төв	26,089.0	26,089.0	0.0
Сум хөгжүүлэх сан	40,000.0	40,000.0	0.0
Орон нутгийн хөгжлийн сан	766,959.5	735,122.9	31,836.6
Нийт дүн	1,957,404.2	1,731,791.2	225,613.0

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2022.12.20-ний өдрийн хуралдаанаар 10/05 дугаар тогтоолоор анх 1,731,791.3 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.07-ний өдрийн 13/02 дугаар тогтоолоор 225,612.9 мянган төгрөгөөр өсгөж 1,957,404.2 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 380,248.9 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 369,955.7 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 619,173.9 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 26,000.0 мянган төгрөгийг

үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 562,025.7 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн болон санхүүгийн дэмжлэгээс авах санхүүжилтээс 1,180,834.1 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 370,514.5 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 50,102.4 мянга, нийт 1,601,451.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 41,021.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	750,367.4	717,036.2	33,331.2	95.6	32,331.2
ИТХ	160,608.9	159,963.4	645.5	99.6	645.5
Соёлын төв	23,089.0	21,532.5	1,556.5	93.3	1,556.5
Сум хөгжүүлэх сан	40,000.0	981.6	39,018.4	2.5	-
Сургууль	116,655.3	111,681.9	4,973.4	95.7	4,973.4
Цэцэрлэг	45,253.0	43,743.6	1,509.4	96.7	1,509.4
ЭМТ	54,471.1	54,466.0	5.1	100.0	5.1
ОНХС	766,959.5	528,752.7	238,206.8	68.9	-
Нийт дүн	1,957,404.2	1,638,157.9	319,246.3	83.7	41,021.1

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,638,157.9 мянган төгрөг буюу 83.7 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 33,331.2 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 645.5 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 238,206.8 мянга, хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүйтэй холбоотой 39,018.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 97,824.6 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11,843.1 мянга нийт 109,667.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 10,204.5 мянган төгрөгийг зарцуулж 99,463.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	2,300.0	107,367.7	109,667.7
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,300.0	95,524.6	97,824.6
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		11,843.1	11,843.1
НИЙТ ЗАРЛАГА	2,300.0	7,904.5	10,204.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,300.0	7,904.5	10,204.5
Төсөвт төвлөрүүлсэн	0.0	99,463.2	99,463.2

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бөмбөгөр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж ахлах аудитор М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дүгээр сарын 28-ний өдрийн 335 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга М.Баярсайхан, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Б.Нарангэрэл нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 80 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1,022,088.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,220.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,154.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.*

4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ байршуулаагүй, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд сумын Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих 293,175.0 мянган 4 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байхад шилэн дансны цахим сайтын худалдан авах ажиллагааны тайланд 37,131.9 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй байна.

4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баацагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 26,948.3 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 26,948.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх 1 албан шаардлага, төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй 2 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 130 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	26,948.3	1	26,948.3			100.0
Зөвлөмж	2	0	1	0			100.0
Нийт	4	26,948.3	1	26,948.3			100.0

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 30,000.0 төгрөгөөр баталж 29,881.1 мянган төгрөгийг зарцуулж 118.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 67 хувийг гамшгаас хамгаалах зардалд, 4.5 хувийг шагнал уралдаан тэмцээний зардалд, 5.4 хувийг сургалт зөвлөгөөн зохион байгуулах зардалд, 11,7 хувийг нохой устгал нийтийн цэвэрлэгээний зардалд, 11.0 хувийг иргэний ирсэн хүсэлтийн дагуу шагналын зардалд тус тус зарцуулсан байна.

4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бөмбөгөр 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд 41 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 27 арга хэмжээ үр дүнтэй, 12 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 2 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай ба жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж хувийг 87.6 хувь гэж дүгнэсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,957,404.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,638,157.9 мянган төгрөгийг зарцуулж 83.7 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 579,173.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 519,811.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлогыг 89.8 хувь буюу 59,362.6 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь бууны албан татвар 1,155.0 мянга, улсын тэмдэгт хураамж 13,833.0 мянга, газрын төлбөр 106,277.5 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 200.0 мянга, газрын дуудлага худалдаа 2,868.0 мянга, малын хөлийн албан татвар 52,295.4 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Бөмбөгөр сумын Засаг даргын харьяа 1 байгууллагыг дүгнэлтэд өгч 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн ба ЗДТГ-ыг хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

**Бөмбөгөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо					Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохиx	Хамрагдсан	Гүйцэтгэсэн			Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулса н	Зөрчилгүй		Хязгаарла лттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс тагталсан	
ЗДТГ	1	1	1				1			
ИТХурал	1	1			1					
ОНХС	1	1			1					
СХС	1	1			1					
НИЙТ ДҮН	4	4			3	0	1	0		0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 752,382.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,461.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 718,921.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага, 30,000.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
	Тоо	Дүн	Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ИТХурал	1	7,733.3					1			
ЗДТГ					2	3,461.0	2	9,867.1	2	30,000.0
ОНХСан							2	23,000.0		
СХС							1	3,734.4		
СТА зөрчлийн дүн	10	77,795.8			2	3,461.0	6	44,334.8	2	30,000.0
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ	1	674,586.2					1	674,586.2		
ИТХурал	1	-					1	-		
Нийцлийн аудитын дүн	2	674,586.2	0	0	0	0	2	674,586.2	0	0
Нийт дүн	12	752,382.0	0		2	3,461.0	8	718,921	2	30,000.0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 77,795.8 мянган төгрөгийн 10 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 674,586.2 мянган төгрөгийн 2 зөрчил тус тус илэрсэн байна.

Хүснэгт 19. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Засаг даргын Тамгын газар		43,328.10			
1	Тайлант онд 9,867.1 мянган төгрөгийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч	9,867.10	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Д.Энхжаргал

Бөмбөгөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна				
2	Байгал хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас ан, агнуурын бүс нутгийн 2 газарт булаг, шандыг хашиж хамгаалах, сэргээн засварлах 30,000.0 мянган төгрөгийн ажлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан байна.	30,000.00	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Д.Энхжаргал
3	Баянхонгор аймгийн Хангайн сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын тэмцээний зардалд 880.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	880.00	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Д.Энхжаргал
4	Сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын хоолны зардалд 2,581.0 мянган төгрөгийг зарцуулсан байна	2,581.00	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Д.Энхжаргал
5	Тухайн байгууллагын санхүүгийн тайланд 5233 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанд 14730 м2 газар бүртгэлтэй байна.	-	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Д.Энхжаргал
6	Тухайн байгууллага нь 2023 сарын 10 сарын 10-д нэгдсэн халаалтад холбогдож Дулааны эрчим хүчээр хангах аж ахуйн гэрээг "Буянт сэргэн" ХХК-тай байгуулсан байна. Уг гэрээнд халаах талбай, эзлэхүүний хэмжээг бичээгүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Д.Энхжаргал
7	Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 584,457.7 мянган төгрөгийн 23 гүйлгээ мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 56,465.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт Засаг дарга нөөц хөрөнгө зарцуулах 1 захирамжийн 1,416.7 мянга, Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 32,246.8 мянган төгрөгийн 5 захирамжийг тус тус мэдээлээгүй байна.	674,586.20	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Д.Энхжаргал
ИТХ		7,733.30			
1	Бараа үйлчилгээний бусад зардлаас хоол хүнсний зардалд 5,233.3 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх хоолны зардалд 2,500.0 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.	7,733.30	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мэндбаяр С.Баттулга
2	Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 157,008.9 мянган төгрөгийн 11 гүйлгээ мэдээлэхээс 1-9 дүгээр сарын 8 гүйлгээний 121,271.5 мянган төгрөгийн 8 гүйлгээг тухай бүр байршуулаагүй 10 сард бөөн дүнгээр мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 26,463.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг хугацаанд байршуулсан байна	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мэндбаяр С.Баттулга

Сум хөгжүүлэх сан		3,734.40			
1	Тайлант оны жилийн эцэст 21 зээлдэгчийн 145,018.8 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас 1 зээлдэгчийн 3734.4 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл хугацаа хэтэрсэн байна.	3,734.40	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Баярсайхан Ж.Сэржмядаг
Орон нутгийн хөгжлийн сан		23,000.00			
1	Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 20000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий сургууль орчны тохижилт хийхээр Ванчиг хан ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд уг ажлыг газар дээр нь шалгахад нэг бүр нь 250.0 мянган төгрөгийн өртөг бүхий цэцгийн мандал 12 ширхэг дутуу хийгдсэн байна.	3,000.00	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Баярсайхан Ж.Сэржмядаг
2	Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн "Хөх толгойн 2-р багт эрчим хүчний өргөтгөл" хийх ажлыг гүйцэтгэхээр "Хас ойл" ХХК-тай 20000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд уг ажлыг холбогдох журмын дагуу хүлээн авч, акт үйлдээгүй байна.	20,000.00	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Баярсайхан Ж.Сэржмядаг
Нийт дүн		77,795.80			

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй байх 213,760.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 213,760.8 мянган төгрөгийн зөрчлийг төслөн зогсоох 2 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1. Албан шаардлага

1. Бууны албан татвар 1,155.0 мянга, улсын тэмдэгт хураамж 13,833.0 мянга, газрын төлбөр 106,277.5 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 200.0 мянга, газрын дуудлага худалдаа 2,868.0 мянга, малын хөлийн албан татвар 52,295.4 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална" 5.1.1 дэх "Жинхэнэ хэрэгжилтийн", Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого, зарлагыг төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөж зарцуулах зөвлөмжийг хүргүүлэв.

2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд сумын Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих 293,175.0 мянган 4 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байхад шилэн дансны цахим сайтын худалдан авах ажиллагааны тайланд 37,131.9 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1 дэх "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн дагуу үнэн зөв мэдээлж байх албан шаардлагыг хүргүүлж байна.

5.2. Зөвлөмж

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр 54.5 дэх хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.4 дэх “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 -д заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бууны албан татвар 1,155.0 мянга, улсын тэмдэгт хураамж 13,833.0 мянга, газрын төлбөр 106,277.5 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 200.0 мянга, газрын дуудлага худалдаа 2,868.0 мянга, малын хөлийн албан татвар 52,295.4 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна	1	176,628.9			1	176,628.9		
Баацагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр тайланг ирүүлээгүй	1	0					1	0
Дүн	2	176,628.9			1	176,628.9	1	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд сумын Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих 293,175.0 мянган 4 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байхад шилэн дансны цахим сайтын худалдан авах ажиллагааны тайланд 37,131.9 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй байна.	1	37,131.9			1	37,131.9		
	1	37,131.9			1	37,131.9		

-----oOo-----